



“МОНРОК” ХХК

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН НУТАГТ ОРШИХ ДООД
ЗООЛУУ ХАР АЛТНЫ ШОРООН ОРД
ТӨСЛИЙН**

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ГҮЙЦЭТГЭГЧ: “МОНРОК” ХХК

Дархан-Уул аймаг

2023 он

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн

удирдлагын газрын дарга: _____(Ц.Уранчимэг)

Дархан-Уул аймгийн Байгаль орчин,

аялал жуулчлалын газрын дарга _____(Г.Батбаяр)

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“МОНРОК” ХХК-ийн гүйцэтгэх захирал _____(Т.Алтанцэцэг)

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ
ДООД ЗООЛУУ ХАР АЛТНЫ ШОРООН ОРД ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
(АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ДУГААР: MV-015091)
(АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2855267)

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн _____(Жаргалнэмэх)

Боловсруулсан:

“Монрок” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн _____(О.Сарантуяа)

ГАРЧИГ

ОРШИЛ

БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр.....	7
1.2 Төслийн зорилго	
1.3 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр.....	7
1.4 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	7
1.5 Төслийн байршил.....	7
1.6 Ордын нөөц.....	10
1.7 Төслийн хүчин чадал.....	12
1.8 2023 онд явагдах уулын ажлын ажиллах горим.....	13
1.9 Ил уурхайн ашиглалтын технологи.....	15
1.10 Усан хангамж.....	16
1.11 Цахилгаан хангамж.....	17

БҮЛЭГ ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....17

БҮЛЭГ ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....29

БҮЛЭГ ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....31

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	33-39
4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	40-41
4.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	41-42
4.4 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох хэмжээний төлөвлөгөө.....	43
4.5 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	43
4.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	44-45
4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	46-57
4.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....	58-60
4.9 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	61
4.10 БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	62
4.11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардал.....	63

ХҮСНЭГТИЙН ДУГААРЛАЛТ

- Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбилцлууд
- Хүснэгт 2. Төслийн талбайн ерөнхий мэдээлэл
- Хүснэгт 3. Ордын алтны нөөц
- Хүснэгт 4. Уурхайд ажиллах үндсэн техникүүд
- Хүснэгт 5. Баяжуулах хэсгийн ажиллах горим
- Хүснэгт 6. Уулын ажлын ажиллах хоног
- Хүснэгт 7. Ил уурхайн ашиглалтын технологийн схем
- Хүснэгт 8. Усан хангамжын төлөвлөгөө
- Хүснэгт 9. ОНТХГ-ийн товч мэдээлэл
- Хүснэгт 10. Археологийн судалгаагаар илрүүлсэн дурсгалуудын солбицол
- Хүснэгт 11. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ тархалтын түвшин үзүүлэлт
- Хүснэгт 12. Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ
- Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 14. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Хүснэгт 15. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 16. Түүх сүёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 17. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 19. Төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх хог хаягдлын ангилал
- Хүснэгт 20. Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Аюултай хог хаягдлын жагсаалт
- Хүснэгт 21. Хог хаягдлын ангилалын код
- Хүснэгт 22. Хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө
- Хүснэгт 23. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- Хүснэгт 24. Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө
- Хүснэгт 25. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

ЗУРГИЙН ДУГААРЛАЛТ

Зураг 1. Ордын байршлын зураг

Зураг 2. Төслийн талбай орчимд тархсан хөрсөн бүрхэвч

Зураг 3. Төслийн талбайд хамгийн ойр орших орон нутгийн ТХГ-ын байрлал, зай

Зураг 4. Археологийн олдворын байршил

Зураг 5. Хог хаягдлын аюулын зэрэглэл, ангилал

Зураг 6. Хаягдал цуглуулах сав

Оршил

“Доод Зоолуухар” нэртэй алтны шороон ордын хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилтыг хангах үүднээс БОАЖЯ-наас байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, журам, стандартуудын хамт нэгтгэн хэрэгжүүлэн ажиллана.

Тус компани Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г 2022 онд мэргэжлийн байгууллагаар дэс дараалалтай хийлгэсэн бөгөөд түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жил бүр төрийн захиргааны төв багууллага (БОАЖЯ) болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага хүсэлтийг хэрхэн хангасныг ч бас нэгтгэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн жилд төрийн захиргааны төв багууллага (БОАЖЯ) ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлэн ажиллана.

Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсЭн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

Энэхүү төлөвлөгөөгөөр байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм журмыг сахин биелүүлнэ.

БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Доод Зоолуухар”-ын алтны шороон орд

1.2 Төслийн зорилго:

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Доод Зоолуухар алтны шороон ордыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

1.3 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Аж ахуйн нэгжийн нэр: “МОНРОК” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011334118

Ашигт малтмалын төрөл: Алт

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015091

Ашиглаж эхэлсэн огноо: 2022-6-сар

Регистрийн дугаар: 2855267

1.4 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Аж ахуйн нэгжийн хаяг:

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 10-р хороо 7 хороолол 31-р байр 24 тоот

Утас: 7000-4266

Гар утас: 9905 6761, 9999 7940

Мэйл хаяг: monrokhhk.12@gmail.com

Ордын байршил: Дархан-Уул аймаг, Хонгор сум, 2-р баг Бууртын хөндий

Доод Зоолуу Харын алтны шороон ордын ил уурхай


Мэйл хаяг: monrokhhk.12@gmail.com

1.5 Төслийн байршил:

Доод Зоолуухар алтны шороон орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 210 орчим км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 75 км, Хонгор сумаас зүүн урагш 45 км, Шарын гол сумаас баруун хойш 7 орчим км-т тус тус зайтай оршино.

“Монрок” ХХК-ийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн солбицлуудыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Зураг 1. Ордын байршлын зураг



Хүснэгт 1 . Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбилцлууд

Д/д	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	22	52.2	49	16	38.91
2	106	22	25.2	49	16	38.91
3	106	22	25.21	49	17	18.41
4	106	23	17.21	49	17	18.41
5	106	23	17.21	49	16	57.92
6	106	22	52.21	49	16	57.92
7	106	22	52.2	49	16	38.91

Хүснэгт 2. Төслийн талбайн ерөнхий мэдээлэл

Ордын нэр	Доод Зоолуухар
Ашигт малтмалын төрөл	Алт
Планшет	М-48-105
Төв цэг	Уртраг: 106°22'49.11'' Өргөрөг: 49°17'11.41''

1.6 Ордын нөөц:

“Монрок”ХХК-н Доод Зоолуухар алтны шороон ордод 2003-2005 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж, 2007 оны 11 сарын 23 өдрийн ЭБМЗ ийн хуралдааны 21/02 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТХЭГ-даргын 2007 оны 12 сарын 28-ны өдрийн 474 тоот тушаалаар ордын нөөцийг 1,006.70 мг/м³(шлихээр) алтны дундаж агуулгатай 475.96 мян.м³ элс, үүнээс шлихээр алтны бодитой (В) нөөц 405.24 кг, боломжтой (С) нөөц 76.30 кг, нийт нөөц (В+С) 481.55 кг, химийн цэврээр алтны бодитой (В) нөөц 355.88 кг, боломжтой (С) нөөц 65.95 кг, нийт (В+С) 421.83 кг нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэл хүлээн авахдаа батлагдсан бодитой (В) болон боломжтой (С) зэргийн алтны нөөцөд тулгуурлан ТЭЗҮ тодотгол-1 ыг 2020 онд батлуулсан. Орд нь III бүлгийн шороон ордод хамаарна.

Хүснэгт 3. Ордын алтны нөөц

Нөөцийн зэрэглэл, блокын дугаар	Талбай, (мян.м ³)	Зузаан, (м)		Эзэлхүүн, (мян.м ³)		Дундаж агуулга, шлихээр (мг/м ³)	Нөөц, (кг)	
		Хуулах хөрс	Элс	Хуулах хөрс	Элс		Шлихээр	Химийн цэврээр
1-С	17.5	19.9	1.28	348.25	22.4	844	18.9	16.56
2-В	34.0	20.9	1.29	710.6	43.86	805	35.3	30.93
3-В	34.0	23.5	22.24	799.0	76.16	829	63.14	55.31
4-В	52.0	24.01	1.97	1248.52	102.44	884	90.6	79.33
5-В	54.0	24.0	1.33	1296.0	71.82	1047	75.2	65.87
6-В	46.0	23.1	1.42	1062.6	65.32	970	63.3	55.5
7-В	34.0	22.0	1.8	748.0	61.2	1286	78.7	68.94
8-С	14.0	21.8	2.34	305.2	32.76	1721	56.4	49.39
Бүгд В+С	254.0			6518.17	475.96		481.54	421.83
Дундаж		22.83	16.7			1006		
Үүнээс: В		23.1	1.66			963	405.24	355.88
С		20.74	1.75			1383	76.3	65.95

1.7 Төслийн хүчин чадал:

Уулын ажилд шаардлагатай үндсэн болон туслах техник, тоног төхөөрөмжүүдийг "Монрок" ХХК-ийн өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмж болон түрээсийн тоног төхөөрөмжийг ашиглахаар тооцоолж төлөвлөв.

Хүснэгт 4. Уурхайд ажиллах үндсэн техникүүд

Д/д	Тоног төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Ажлын зориулалт
1	Экскаватор	Hyuandai R500LC-7,	Утгуурын багтаамж	м ³	3.0	Хөрс хуулалт
2	Экскаватор	Doosan-DX500LCA	Утгуурын багтаамж	м ³	3.0	Хөрс хуулалт
3	Экскаватор	Doosan-DX500LCA	Утгуурын багтаамж	м ³	3.2	Элс олборлолт, хөрс хуулалт
4	Экскаватор	CAT320CL	Утгуурын багтаамж	м ³	1.2	Туслах ажил
5	Автосамосвал	Howo	Техникийн даац	тн	25	Хөрс тээвэрлэлт
6	Бульдозер	Komatsu D-85	Хусуурын хамах чадвар	м ³	8.0	Хөрсний овоолго
7	Утгуурт ачигч	XZ656L	Утгуурын багтаамж	м ³	3.0	Элсний овоолго
8	Утгуурт ачигч	XZ656L	Утгуурын багтаамж	м ³	3.0	Элсний овоолго
9	Автогрейдер	CAT 14H	Хусуурын урт	м	16	Зам арчилгаа
10	Усны машин	FAW - FX30	Танкны багтаамж	тн	20	Зам усалгаа

Баяжуулах хэсэг: Зоолуухарын алтны шороон ордын лабораторийн технологийн туршилтын тайланг Шинжлэх Ухаан Академийн Эрдэс боловсруулалтын технологийн шинжилгээний төвд гүйцэтгүүлсэн.

2023 онд 144.9 мян.м³ элс олборлон баяжуулж 116.4 кг алт борлуулахаар төлөвлөв. Метал авалт 87.2%, технологийн хаягдал 12.8%, гарц 0.08% байхаар тооцож тус төлөвлөгөөг боловсруулав. 2023 онд Монгол улсад үйлдвэрлэсэн ГМ-60 угаах төхөөрөмж, БНХАУ-ын 7-S сэгсрэх ширээ, Монгол улсад үйлдвэрлэсэн хоригт цорг /шлюз/, ОХУ-д үйлдвэрлэсэн Д/320/500, Д-200/70, ЭЦВ-10-65 усны насосуудыг ашиглана. 2020-2021 онд бичиг баримтын бүрдэл дутуу, хөрөнгө оруулалтгүй зэрэг үндэслэлээр олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй. Иймд 2022 онд тухайн тоног төхөөрөмжүүдийг II улиралаас ашиглаж эхэлсэн.

Хүснэгт 5. Баяжуулах хэсгийн ажиллах горим

Үзүүлэлт	2023 онд
Жилийн хуанлийн хоног	365 хоног
Жилд ажиллах хоног	140 хоног
Амралт, баяр ёслолын өдрүүд	2 хоног
Урсгал засвар хийх өдрүүд	4 хоног
Цаг агаарын хүндрэл тооцох өдрүүд	4 хоног
Жилийн бодит ажиллах хоног	140 хоног
Элс угаах ажлын хоног	120 хоног
Ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	8-10 цаг

Бүтээгдэхүүн гаргалт: Баяжуулах хэсэг нь алт агуулагч элсийг угаан баяжуулах төхөөрөмж, алт гүйцээн ялган хадгалах цех зэргээс бүрдэнэ. Алт агуулагч элсийг угаан баяжуулах ажил нь зөвхөн дулааны улирлын 60 хоногт явагдана. Элсийг угааж баяжуулахад Монголд үйлдвэрлэсэн ГМ-60 маркийн 60 м³ /цаг хүчин чадалтай угаах төхөөрөмжийг ашиглах юм.

1.8 2023 онд явагдах уулын ажлын ажиллах горим:

Ажлын горим: Уурхайн ажиллах горимыг 2023 оны уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан дулааны улирлын 5 сар буюу 150 хоногийн хугацаанд, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөөд байна. Уурхай нь 4-р сараас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 5-р сарын 1-нээс 9-р сарыг дуустал ажиллахаар төлөвлөв. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амрахаар төлөвлөсөн.

Хүснэгт 6. Уулын ажлын ажиллах хоног

Үзүүлэлт	2023 онд
Жилийн хуанлийн хоног	365 хоног
Жилд ажиллах хоног	150 хоног
Амралт, баяр ёслолын өдрүүд	2 хоног
Урсгал засвар хийх өдрүүд	4 хоног
Цаг агаарын хүндрэл тооцох өдрүүд	4 хоног
Жилийн бодит ажиллах хоног	140 хоног
Элс угаах ажлын хоног	120 хоног
Ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	8-10 цаг

2023 онд явагдах уулын ажил: 2023 онд ордын 5-В, 6-В гэсэн блокууд олборлолтонд өртөхөөр байна. Энэ үед уурхайн урт дунджаар 545 м, өргөн 135-230 м, гүн +860 м түвшин хүртэл буюу 22.0 м байх бөгөөд уурхай 12.03 га талбайг хамарч байна. Тус онд дээрх блокуудаас нийт 2623.9 мян.м³ хөрс хуулж, 144.93 мян.м³ элс олборлон баяжуулж дунджаар 585 мг/м³ -ийн агуулгатай 116.4 кг алт /химийн цэврээр/ олборлон борлуулахаар байна.

Үржил шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа хайгуулын шугамын дагуу баруун урдаас зүүн хойд зүгт 0.3 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж, экскаватор-автосамосвалын хослолоор уурхайн баруун талд салхины нөмөр газар тусгайлан сонгосон талбайд тээвэрлэн овоолно. Үржил шимт хөрсний овоолгыг 3-5 м өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөв.

Хөрсний дотоод овоолго: Талбайн үржил шимт хөрсийг хуулсаны дараа 5,6-В блокийн хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөв. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлтээс шалтгаалан 5 м байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө: Энэ оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг улирал бүрд гүйцэтгэх уулын ажлын эцсийн байдлын хүрээнд хийгдсэн уулын ажлын тооцоо, зургийг үндэслэн боловсруулав. Ордоос 2023 онд 2623.9 мян.м³ хөрс хуулж, 144.93 мян.м³ элс олборлон баяжуулж дунджаар 585 мг/м³ -ийн агуулгатай 116.4 кг алт борлуулахаар төлөвлөв. Уулын ажлын тооцоонд технологийн шаардлагын дагуу ургамлын шимт бүрхэвчтэй хөрсийг тухайн районы үзүүлэлтээр 0.3 м-ээр авсан.

Ашиглалтын систем: Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн параметруудийг ордын чулуулгийн физик механик шинж чанар болон ажиллах тоног төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлтүүдэд үндэслэн сонгосон.

Доголын өндөр: Элсний хаягдал, бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг Нд=5 м байхаар сонгосон.

Ажлын бус доголын өндөр: Уурхайн ажлын доголыг ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед доголудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэх ба ажлын бус доголын өндөр /доголын хаалт/ нь 10 м байна.

Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг: Ил уурхайн хажуугийн өнцгийг ордын чулуулгийн физик-механик шинж чанарт үндэслэн тогтоосон. Уурхайн ашиглалтын технологийн элементүүд болох ажлын болон ажлын бус доголын өндөр ба доголын өнцөг, тээврийн ба аюулгүйн тавцангийн өргөн зэрэг ил уурхайн уулын ажлын параметруудээр байгуулж үзэхэд ерөнхий хажуугийн өнцөг 48-52 градус байна.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн физик механик шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож үндсэн чулуулагт 53 градус байхаар сонгосон.

Ажлын талбайн өргөн: Ажлын талбай нь тухайн догол бүрт хэрэгжүүлэх технологийн процессуудыг явуулах орон зайн нөхцлийг хангахад зориулагдана. Тээврийн аюулгүй зай, техникийн ажиллах нөхцөл зэргийг тооцож үзэхэд ажлын талбайн оновчтой өргөнийг 65 м ба түүнээс дээш байхаар сонгож төсөлд тусгасан.

Уурхайн хил хязгаар, үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо:

Доод Зоолуухар алтны шороон ордын алт агуулсан элс болон хучаас хөрсний давхаргын зузаан, урт, өргөн, унал, ордын хил хязгаар, чулуулгийн тогтоц, ус агуулагч давхарга зэргийг геологийн хайгуулын явцад өрөмдлөгийн ажлын үр дүнгээр тогтоосон бөгөөд нөөцийг геологийн зүсэлт, блоккийн тооцооны аргаар тодорхойлсон болно. Доод Зоолуухар сэвсгэр хурдасны зузаан дунджаар 22.83 м хүрэх бөгөөд хурдсын литологи нь хоорондоо төдийлөн ялгаатай бус хайгуулын 12-р шугамаас эхлэн хайрга, хайрганцарын хольц ихсэх ба түүнээс доошлох тусам хүрэн улаан өнгийн наанги шаврын зузаан ихсэж 10 м-т хүрнэ. Металл агуулагч элсний давхарга нь үндсэн 1 давхрагаас бүрдэх бөгөөд энгийн тогтоцтой, цайвар шаргал, бор шаргал өнгөтэй 1.67 м дундаж зузаантай, давхаргын урт 1.2 км, давхаргын өргөн 40-250 м байна.

Үйлдвэрлэлийн нөөц:

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ордын уул техникийн нөхцөл, ашиглалтын систем зэрэгт үндэслэн нөөцийн блок бүрээр тооцоолсон бөгөөд элсний давхаргын зузаан дунджаар 1.67 м байна. Элсний давхаргын 3-н хэмжээст загварыг Датамайн Студио ОП (Datamine Studio OP) программыг ашиглаж гүйцэтгэсэн. Бохирдол: Ил уурхайн олборлолтын үеийн элсний бохирдлын тооцоог хийхдээ элсний давхаргын тааз болон улны талбайг тооцож улнаас 20 см, таазнаас 10 см-ээр бохирдуулж авахаар тооцсон. Хаягдал: Ил уурхайг ашиглах явцад олборлолтын үеийн хаягдал болон тээвэрлэлтийн үеийн хаягдлыг үүсэхгүй байхаар тооцсон.

Уурхайн нөхөн сэргээлт: Доод Зоолуур хар алтны шороон орд нь 2022 онд уулын ажил эхэлсэн ба тус онд хангалттай хоосон орон зай гараагүй тул хөрсийг уурхайн хойд талд байрлах гадаад овоолго руу зөөнө. Ашиглалтын жилийн дунд үед хоосон орон зай гарахад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ. 2023 онд уурхай 12.03 га талбайг эвдрэлд оруулах ба түүнээс 5.5 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ. Биологийн нөхөн сэргээлтийг 0.89 га талбайд шимт хөрсийг хадгалан хамгаална.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн хийж байгаа ба мод тарих талбай нь тусгай зөвшөөрлийн талбайгаас хол учир усны тооцоонд байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд зарцуулах усыг тооцоогүй болно.

1.9 ИЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ:

Доод Зоолуухар алтны шороон орд нь үндсэндээ 1 давхаргаас бүрдэнэ. Алт агуулсан элсний давхаргын дундаж зузаан 1.67 м давхаргын урт 1.5 км, давхаргын өргөн 40-250 м, хучаас хөрсний дундаж зузаан 22.83 м байна. Ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил уурхайн аргаар, автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ (тодотгол-I)-ийг боловсруулсан.

Ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил уурхайн аргаар, автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглана.

Хүснэгт 7. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1. Ухаж ачих 1.2. Тээвэрлэх 1.3. Овоолох
	2. Элс олборлолт	2.1. Ухаж ачих 2.2. Тээвэрлэх 2.3. Овоолох

Ил уурхайн хөрсийг уурхайн баруун хойно байрлах хөрсний гадаад овоолгод хураах ба ашиглалтын 2023 оны дунд үеэс эхлэн хөрсийг уурхайн дотоод овоолгод байршуулна. Элсний овоолгыг угаан баяжуулах хэсгээс 50 метрийн зайд байгуулна.

1.10 Усан хангаж

Уурхайн унд-ахуйн буюу хотхоны усны хэрэглээг Шарын голын шаазгайт багийн иргэнтэй гэрээ байгуулсан худгаас хангана. Харин угаан баяжуулах хэсэг болон ил уурхайн усны хэрэглээг уурхайн шүүрэлтийн усыг цуглуулж хангана. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг “Их худаг”- ийн аргаар тооцоход тухайн жилийн ил уурхайн карьераас хамаарч 17.7 л/с шүүрч орж ирэхээр байна. Энэ нь уурхайн нийт усны хэрэглээ болох 17.4 л/с-ийг хангаж байна. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг зумпанд цуглуулах ба зумпнаас угаан баяжуулах хэсгийн цэвэр усан сан руу татаж ашиглана.

Хүснэгт 8. Усан
хангамж
төлөвлөгөө

№	Хэрэглэгчдийн жагсаалт		Эх үүсвэр	Хэмжих нэгж	Тоон утга	Шоометр тутам дахь үнэ тариф (төгрөг)	Төлбөрийн хэмжээ (сая.төг)
1	2	3	4	5	6	7	8
1	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ	Зөөвөр	м3/жил	1,230.00	779.50	0.959
2	Олборлох үйлдвэрлэлийн хэрэглээ (уурхай) хэрэглээ	Олборлох үйлдвэрлэлийн (ил, далд)	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	0.00	0.00	0.00
3	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	Эргэлтийн усны хэмжээ	Үүсмэл нуур	м3/жил	422,436.00	0.00	0.00
3	усны хэмжээ	Нэмэлт	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	181,044.00	779.50	141.124
3	усны хэмжээ	Нийт	- - -	м3/жил	603,480.00	0.00	0.00
3	Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усны эзлэх хэмжээ		- - -	%	70.00	0.00	0.00
4	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх		Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	16,200.00	779.50	12.628
5	Усыг шавхан зайлуулах	Усыг шавхан зайлуулах	Гүн (шүүрэл, худаг)	м3/жил	8,502.00	779.50	6.627
6	Эрэл хайгуулын өрөмдлөг хийх	Эрэл хайгуулын өрөмдлөг хийх	- - Сонгох - -	м3/жил	0.00	0.00	0.00
7	Бусад (Авто зам, Барилга, Хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Эрчим хүч, Газар тариалан г.м)	Бусад (Авто зам, Барилга, Хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Эрчим хүч, Газар тариалан г.м)	- - Сонгох - -	м3/жил	0.00	0.00	0.00
Нийт хэрэглээ					629,412.00	- - -	161.338

1.11 Цахилгаан хангамж

Доод Зоолуухар алтны шороон ордын цахилгааны хэрэглээг Шарын голын уурхайн цахилгааны үндсэн сүлжээнээс 400кВт-ын шугамаар салаалж авсан.

БҮЛЭГ ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал: Алтны шороон орд төслийн байршил нь Монгол орны уур амьсгалын тоон ангилалын Булган-Сэлэнгэ-Архангайн ойт хээрийн хэсэгт хамаарна. Энэ хэсэг нь Сибирээс түрж орж ирсэн байгалийн нэг хэсэг байдгаараа онцлогтой бөгөөд Монгол орны ойт хээрийн өмнөд хил болох тул хур тундасны хэмжээнээс зуншлагын байдал шууд хамаарч ургац болон газрын бүтээмжийг хязгаарлах хүчин зүйл нь болдог, уур амьсгалын эрс тэс байдал тод илэрцтэй байна.

Районд жилдээ 2585 цаг нар гийгүүлдэг байна. Нар гийгүүлэх цагийн сарын нийлбэр нарны өндрөөс хамаарч 12 дугаар сард хамгийн бага-145.2 цаг, 5 дугаар сард хамгийн их -314.8 цаг байна. Жилийн дундаж агаарын температур -0.8°C орчим байна. Хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Хонгор суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Хонгор суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг. Дунджаар хаврын эцсийн цочир хүйтрэл агаарт 5 дугаар сарын III-10 хоногт, намрын эхний цочир хүйтрэл 9 дүгээр сарын II-10 хоногт ажиглагддаг.

Агаарын температурын хоногийн агууриг дунджаар $10.0 - 12.9^{\circ}\text{C}$ байх бөгөөд хавар, намрын улиралд $13.7-14.8^{\circ}\text{C}$ болж ихсэнэ.

Хөрсний гадаргын жилийн дундаж температур 2.5°C дулаан байна. Хамгийн их нь 2010 онд 71.2 градус /Шарын гол суманд 7 сард/ хүрч халсан, хамгийн бага нь 1999 онд - 49.2 градус /Дархан суманд 1 сард/ хүрч хүйтэрч байсан.

Хөрсний гадаргын температурын дундаж утга хүйтний улиралд $-19.3...-24.4^{\circ}\text{C}$, дулааны улиралд $20.6...25.2^{\circ}\text{C}$, шилжилтийн улирал (3,4,5 ба 9,10,11 сарууд)-д $-11.1...15.6^{\circ}\text{C}$ орчим байна.

Районд дунджаар 317.5 орчим мм хур тунадас унах бөгөөд түүний 90.0 хувь орчим нь жилийн дулаан улиралд /4-9 дүгээр сарын хооронд/ орно. Жилийн хүйтэн улиралд хур тунадас тун бага унана.

2008-2020 оны хооронд хур тунадасны хэмжээ ерөнхийдөө хэлбэлзэл ихтэй зарим онд буурсан, зарим онд өссөн дүр төрхтэй байна. Тус хугацааны цуваанаас харахад 2014 онд хамгийн бага буюу 262 мм хур тунадас орсон бол 2014 оноос хойш өссөн байна.

Агаарын харьцангуй чийгшил нь температурын эсрэг явцтай, жилдээ 66% байдаг нь уг район нь чийглэгдүү гэдгийг харуулж байна. Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их 72-78%, зуны саруудад 56-66%, хавар 39.8-49% байдаг.

Олон жилийн дундаж байдлаар төслийн районд 27 өдөр цас орж, 53 өдөр бороо ордог ажээ. Жилдээ дунджаар 18 өдөр аянга цахилгаантай байдаг, хамгийн олондоо 25 өдөр хүрч байсан аж. Аянгатай бороо жилдээ дунджаар 28.0 цаг үргэлжлэх бөгөөд 7 дугаар сард хамгийн удаан үргэлжилдэг байна. Аянгатай борооны 56.6 хувь нь 30 минутаас 2 цаг орчим үргэлжилнэ.

Аянга цахилгааны 74.0 хувь өдрийн 12.0-оос оройн 21 цагийн хооронд тохиолдох бөгөөд шөнө дундаас хойш аянга цахилгаан болох нь тун ховор.

Төслийн районд жилдээ 1.0 өдөр /10 жилд 10 өдөр/, хамгийн олондоо жилдээ 3 өдөр мөндөр орно.

Төслийн бүс нутагт жилийн дундаж салхины хурд 2.0 м/с орчим, хаврын саруудын салхины дундаж хурд 3.1-3.2 м/с хүрдэг байна. Салхины үнэмлэхүй их хурд хүйтний улиралд олон жилийн дунджаар 20-23 м/сек, дулааны улиралд 25-32 м/сек хүрдэг.

Салхины хурдны жилийн явцад хавар, намрын улиралд 2 удаагийн максимум утга, өвөл, зуны улиралд 2 удаа минимум утга ажиглагдах бөгөөд хаврынх нь үндсэн их утга байх агаад чухам агаар, хөрс хамгийн хуурай үе, салхины хүч хамгийн их үе хоёр давхцахаас болж жилд тохиолддог хүчтэй салхитай болон шороон шуургатай өдрийн тооны 60 гаруй хувь нь зөвхөн хаврын 3 сард тохиолдоно. Салхины хүч тодорхой хэмжээнд хүрэхэд цасан, шороон шуурга шуурах, салхины ачааллын нөлөөгөөр янз бүрийн барилга байгууламж эвдрэх зэргээр улс ардын аж ахуйд хохирол учруулж болзошгүй тул цаг уурт 15 м/с-ээс их хурдтай салхийг хүчтэй салхи гэж үздэг. Хөрш зэргэлдээ Баруун хараагаар баримжаалбал төслийн районд жилд 17.3 өдөр хүчтэй салхи тохиолдоно.

Гадаргын ус:

Доод зоолуу харын алтны шороон орд орчмын гадаргын усны сүлжээ нь Хойт мөсөн далайн ай сав Хараа-Шарын голын сав газарт багтдаг. Хараа гол нь Хэнтийн нурууны баруун, баруун өмнөд хажуугийн салбар уулсаас эх авах Мандал гол, Баян, Сөгнөгөр голтой нийлж, Хараа гол хэмээн нэрлэгдэнэ. Шарын гол нь Хэнтийн нурууны салбар Хар Модот уул (1650 м)-ын өврөөс эх авах Гахайтын гол, Дарьтын давааны арын горхитой нийлж, Шарын гол болно.

Талбайн хэмжээнд гадаргын усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Шарын гол юм. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25 мм-ээс дээш байна. Борооны үерийн хамгийн их урсацын модуль 0.2-ээс дээш байдаг ба Шарын голын савд дулааны улиралд 230-270 мм, хүйтний улиралд 20-30 мм, жилд дунджаар 250-300 мм хур тунадас унана. Хур тунадасны мэдээгээр хангамшлын муруйг байгуулан тооцож үзэхэд, 1 хувийн хангамшил хур тунадасны эрчимшил 87.8 мм/цаг байна. Шарын гол бол 5-р эрэмбийн гол. Шарын гол нь Хэнтийн нурууны салбар Хар Модот уул (1650 м)-ын өврөөс эх авах Гахайтын гол, Дарьтын давааны арын горхитой нийлж, Шарын гол болно. Энэ уулын араас араас түүний томоохон цутгалын нэг Хүйтэн гол эх авна. Шарын голд Хавчуу, Шивэрт, Шаазгайт, Хуст, Хүйтэн зэрэг олон гол горхи цутгана. Ус хурах талбай 2839.3 км², 162 км урт, хэвгий нь 0.0044 байна. Голдрилын дундаж өндөр 762 м, ус хагалбарын шугамын урт 445.2 км, түүний дундаж өндөр 1320.0 м, голын сүлжээний нягт дунд зэрэг 0.32 км/км², ус хурах талбайн дундаж өндөр 921 м, хөндийн гүн дунджаар 558 м, ус хурах талбайн дундаж өргөн 17.5 км, сав газрын суналын зэрэг 9.3, ус хагалбарын шугамын тахиршлын зэрэг 2.3, хажуугийн хэрчигдэл 1.14 байна. Шарын голын усны олон жилийн дундаж өнгөрөлт Дархан-Уул аймгийн Шарын гол сум орчимд 1.65 м³/с байна.

Гадаргын усны чанар: Дархан-уул аймгийн гадаргын усны 2018 оны төлөв байдлын тойм мэдээнээс харахад усны бохирдлын индексийн үнэлгээгээр Шарын гол УБИ 0.52-0.83 буюу усны чанарын зэрэг-II, "ЦЭВЭР" ангилалд үнэлэгдсэн. Гол бохирдуулах

зүүлэлтүүдийн 2018 оны жилийн дундаж агууламж нь MNS4586:98 усны чанарын стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байсан ба шинжилгээний дүнг дараах хүснэгтээр харуулав.

Газрын доорх ус: Тус талбай нь Хангай-Хэнтийн гидрогеологийн мужийн Орхон голын сав газрын хэмжээнд, түүний баруун гар талын цутгалуудын нэг болох Хараа голын сав газрын дунд, Шарын голын сав газрын доод хэсэгт байрлана.

Тухайн бүс нутагт өмнө хийгдсэн судалгааны байдал: Судалгаа явуулсан Шарын гол сумын нутаг дэвсгэрийг хамруулсан судалгааг 1957-1960 онуудад 1:200000 геологийн зураглалын ажлыг И.Б.Полищукийн удирдлагаар гүйцэтгэн судалгааны талбайд тархсан хурдас, чулуулгийн бүрэлдхүүн, давхрага зүй болон гүний чулуулгийн бүтцэд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийсэн байдаг.

Харин 1962-1963, 1973-1974 онуудад гидрогеологийн төрөлжсөн судалгаа явуулж, үр дүнгээр нь дунд-дээд юрийн тунамал хурдас, түрүү палеозойн гүний шургамал чулуулгийн усжилтийг нарийвчлан тогтоосон байна.

Төслийн талбайн байршил нь гидрогеологийн региональ зүй тогтол: Судалгааны бүс нутаг болох Шарын гол болон түүний цутгал голуудын хөндий, Бууртын хөндий орчмын газрын гадарга нь орчин үеийн хотгор гүдгэрийн хэв шинжийн онцлогийн хувьд далайн түвшнээс дээш 840,0-960,0м үнэмлэхүй өндөртэй уулс хоорондын тэвш маягийн гадаргатай суумал хөндий бөгөөд голуудын хөндийн ай сав 1065-139 м үнэмлэхүй өндөртэй бэсрэг хэлхээ намхан уулсын муж хүрээлэн байдаг. Энэ талбайд Шарын гол болон Шаазгайтын хөндийн ай савын өргөн нь зарим хэсэгтээ 0,8-1,2 км хүртэл өргөснө. Бууртын хөндий өргөн бөгөөд ерөнхийдөө 1,2-2,0 км болдог.

Ус зүй: Бүс нутгийн хэмжээнд Шарын гол болон түүний цутгал Буянт, Хавчуу, Шаазгайтын голуудын ай сав газард оршино. Талбайн хэмжээнд усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол Шарын гол юм. Шарын голын хажуугийн цутгал болох байнгын урсгал устай Шаазгайт, Хавчуу, Мухар голууд нь жижиг горхиуд бөгөөд усны өргөн нт 0.5-3.0 м, гүн нь 1.5 м-т хүрнэ. Голын ус нь 10-р сарын сүүл үеэс хөлдөж, 5- сарын эхээр хайлж урсдаг. Шарын гол байнгын урсацтай байдаг ч сүүлийн 3 жилд урсац багас шургасан байдал үүссэн. Харин Хавчуу, Шаазгайн гол нь хур тунадас элбэгтэй үед урсацтай байдаг.

Геологи-гидрогеологийн тогтоц: Судалгааны талбайн нутаг дэвсгэрт дунд-дээд юрийн настай Шарын голын свитын чулуулаг, дөрөвдөгчийн сэвсгэр хурдас, түрүү палеозойн болон дунд-хожуу девоны гүний шургамал чулуулууд нилээд тархсан.


Дээд протерозойн хувирмал чулуулаг: Хар ямаатын уулын уулархаг мужийн усан хагалбарын хэсэгт харьцангуй хязгаарлагдмал бичил талбайд дунд-хожуу девоны гүний шургамал чулуулагт кменолти хэлбэрээр тарсан. Геологи-литологийн бүрэлдхүүнд саарал өнгийн жижиг ширхэгтэй биотит, амфибол–биотит, занар зонхилно. Чулуулгийн зузаан бүс нутгийн хэмжээнд 300-500 м багагүй байна.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай байрлах нутаг дэвсгэр нь хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн захын 39-р тойргийн нутагт хамрагдана (Монгол Улсын Үндэсний Атлас, 2009).

Тус орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун хойд салбар уулсуудын хүрээнд Шарын голын районд багтах бөгөөд түүний баруун цутгал болох Зоолуухарын хөндийд дээд аманд байрлана. Гадаргуугийн хагийн нам цэг нь Шарын голын хөндийд 790 м, хамгийн өндөр цэг нь ордын зүүн хэсэгт орших Их Дархан Уул дайлан түвшнээс дээш 1242.3м хүрэх бөгөөд харьцангуй өндөржилт нь 50-600 метрийн хооронд хэлбэлзэнэ.

“Доод Зоолуухар алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн талбай орчмын нутагт тархсан хөрсийг ялгаж тогтооход дараах үндсэн дэд хэв шинжид хамрагдах хөрсүүд тархсан байна. Үүнд:

- Ердийн хархүрэн ба нугат-хүрэн хөрс
- Нугат намгийн цэвдэгт карбонатлаг ба нугын цэвдэгт карбонатлаг хөрс
- Уулын хархүрэн хөрс



Зураг 2.Төслийн талбай орчимд тархсан хөрсөн бүрхэвч

Хөрсөн дэх химийн үндсэн шинжүүдийг дүгнэвэл ялзмагийн агууламж дундаж, маш хүчтэй хүчиллэг-шүлтлэг урвалын орчинтой, давсжилтгүй, цахилгаан дамжуулах чанар (ЕС2.5) сул байна. Хөрсөн дэх макро шим тэжээлийн бодисын хангамж 23.2-50.8 шим тэжээлийн үзүүлэлт сайтай. Нарийн элс давамгайлсан хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрстэй байна. /шинжилгээний дүнг хавсаргав/.

Ургамлан бүрхэвч: Бууртын хөндийд урьд нь үнээний ферм байсан тул тус хөндий, мөн Баянголын татам тэр чигтээ маш их талхагдсан байв. Одоогоор нөхөн сэргэж байгаа хэдий ч хуучин байсан хашаа саравч орчмоор нилдээ халгай ургажээ. Хөндийн бэлчээр урьд нь

алаг өвст нуга байх ёстой байсан бол одоо хээрийн ургамал холилдон ургаж, ялангуяа Хазааргана зонхилох болжээ. Энэ байдал тухайн газар хуурайшиж байгаагийн илрэл болно. Энд нуга болон хээрийн гаралтай ургамал нийлээд 31 зүйл дээд ургамалтай. Эдгээрийн дотор 7 зүйл үетэн, 2 зүйл улалж, 2 зүйл нэг наст ургамал, мөн бэлчээр талхагдлын шалгуур ургамал 8 зүйл байна. 1 га талбай дахь ургацын хэмжээ 7,5 ц буюу 750 кг байна. Алаг өвс-Зогдор Улалж Дунд Тавилганат нугад нугын гол зонхилогч нь ойн сөөгөн ташингын үндсэн элемент болох Дунд Тавилгана (*Spiraea media*) бөгөөд түүнийг дагалдах ургамлууд нь ихэнхидээ нугын ургамлууд юм. Бууртын хөндийн урд арын бэлээр эмжээрлэн тархсан байна. Бороо хур элбэгтэй олон жил дараалвал эргээд Нарсан ой болж нөхөн сэргэх боломжтой, харин хуурай гантай үе удаан үргэлжлэх, мал хэт их бэлчээх зэрэг сөрөг үйл ажиллагааны явцад бүрмөсөн устаж хээрт шилжих эрсдэлтэй. Нийтдээ зүйлийн бүрдлээр баялаг, 41 зүйлтэй. Эдгээрийн дотор 1 зүйл сөөг, 7 зүйл үетэн, 2 зүйл улалж, 30 зүйл олон наст алаг өвс байна. 1 га талбай дахь ургацын хэмжээ 20 ц буюу 2016 кг байна. Нуга, хээрийн алаг өвс- Дунд Тавилганат нугын хээрд зарим газартаа хэсэг бөөн Хус-Нарсан ойтой, ихэнхдээ Нарс маш сийрэг тархсан байлаа. Бууртын хөндийн урд уулын ар хажуугийн дээд хэсгээр тархана. Байгалийн аясаар юмуу хүний нөлөө, түймрийн нөлөөгөөр юмуу ямар ч байсан талбайгаа хумиж байна. Гэхдээ түүний сөөгөн ташингаас Дунд Тавилгана их хэмжээгээр үлдсэн байгаа нь хур бороо элбэгшвэл эргээд нөхөн сэргэхэд суурь болох юм. Энэ газарт нийт 50 зүйл дээд ургамалтай. Эдгээрээс 2 зүйл мод, 5 зүйл сөөг, 6 зүйл үетэн ургамал, 2 зүйл улалж, 35 зүйл алаг өвс байна. 1 га талбайн ургац сөөг, ба модыг оролцуулахгүйгээр 42.0 ц/га.


Амьтан: Төслийн талбайн амьтны аймгийн зүйлийн бүрдлийг хээрийн судалгааны материал, холбогдох ном, сурвалж, зэргэлдээх уурхайн байгаль орчны судалгаа, мониторингийн тайланд тулгуурлан боловсрууллаа. Үүнд 25 зүйлийн хөхтөн, 200 гаруй зүйлийн шувуу (нүүдлийн шувууд орсон тоо), 7 зүйлийн мөлхөгч амьтан тохиолдох боломжтой байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Байгаль орчны төлөв байдлын судалгааны хүрээнд БОАЖЯамны мэдээллийн сан, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүртгэлийг тулган орд газрын ойр орчимд тусгай хамгаалалттай газар нутаг бий эсэхийг тодруулж үзвэл төслийн талбай орчмын 60 км радиуст улсын тусгай хамгалалттай газар байхгүй байна.

Дархан Уул аймгийн Хонгор болон Шарын гол суман дахь Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн мэдээллийг байгаль орчны мэдээллийн сангийн www.eis.mn сайтын Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сангаас шалгахад нийт 30н ОНТХГ нутаг байгаагаас төслийн талбайд хамгийн ойр байрлах тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 9. ОНТХГ-ийн товч мэдээлэл

ОНТХГ-ийн нэр	Тусгай хэрэгцээнд авсан огноо	Тусгай хэрэгцээнээс гарах огноо	Зориулалт	Зай, км	Байрлал
Шаазгайт	2015-12-18	2030-12-18	Бусад	3.6км	Төслийн талбайгаас зүүн хойд зүгт
Дархан Уул хайрхан	2007-05-10	-	Бусад	-	Төслийн талбайн зүүн урд үзүүрт 12га талбайтай давхцалтай
Олон хөтөл даваа	2014-05-20	2019-05-20	Бусад	4.5км	Төслийн талбайгаас зүүн зүгт
Дархан хөтөл даваа	2014-05-20	2019-05-20	Бусад	5.2км	Төслийн талбайгаас зүүн зүгт
Шарын хөндий	2014-05-20	2019-05-20	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	6км	Төслийн талбайгаас зүүн урд зүгт



Зураг 3. Төслийн талбайд хамгийн ойр орших орон нутгийн ТХГ-ын байрлал, зай


Археологи болон Угсаатны зүйн судалгаа: Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 5-р бүлгийн 27.8-д /соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна/

заасны дагуу ШУА-ын Түүх, Археологийн Хүрээлэнтэй гэрээ хийж 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр төслийн талбайд археологийн хайгуулын судалгааг хийлгүүлж дүгнэлт гаргуулсан байна. Мөн 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Археологийн судалгаа. Хайгуул, судалгааны ажлын хүрээнд тус талбайгаас эртний түүхийн дурсгал илрээгүй. Энэ нь уг талбайн гадаргын тогтоцтой холбоотой юм. Гэвч талбайн гадна талд холгүй орших Сөн толгойн энгэрээс эртний нүүдэлчдийн булш оршуулгын дурсгал 4-ийг илрүүлэн баримтжуулсан байна. Эдгээр дурсгалууд нь талбайн зүүн талд буюу нутгийн иргэд Сөн толгой хэмээн нэрлэх орой хэсгээрээ боржин хадтай намхавтар уулын энгэрт байрлана. Энэ газарт чулууг газарт хавиргалуулан суулгаж үйлдсэн дөрвөлжин хэлбэрийн хашлагатай (хашлага чулууны зарим нь газрын хэвгийн даган унасан) булш 2 ш, дундаж хэмжээтэй чулуугаар дугуй хэлбэрийн дараас үйлдсэн булш 2 ш нийт дөрвөн дурсгал байсныг илрүүлэн баталгаажуулав. Булш оршуулгын газрын дурсгалын гадаад зохион байгуулалт, орших орчин зэрэгт дулдуйдан дөрвөлжин хэлбэрийн хашлага бүхий дурсгалуудыг хүрэл зэвсгийн үед, харин дугуй хэлбэрийн битүү овгор дараас бүхий дурсгалуудыг дундад зууны үед холбогдоно хэмээн үзэж байна. Уг дурсгалууд нь талбайн шугамнаас гадагш 180-270 м зайд байрлах бөгөөд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахдаа эдгээр дурсгалын хадгалалтын байдалд анхааран ажиллах хэрэгтэй. Мөн түүнчлэн газрын гадарга дээр мэдэгдэх ямар нэг шинж тэмдэггүй, хөрсөнд булшлагдсан дурсгал байхыг үгүйсгэхгүй бөгөөд ашиглалтын үйл ажиллагааны явцад анхаарал болгоомжтой байж, ямар нэг олдвор, эд зүйл илэрсэн тохиолдолд даруй мэргэжлийн байгууллагад хандахыг зөвлөсөн байна.

Хүснэгт 10. Археологийн судалгаагаар илрүүлсэн дурсгалуудын солбицол

№	Дурсгалын дугаар	Солбицол		Хэмжээ (м)	Дурсгалын төрөл
		N	E		
1	Сөн толгой-01	49 17 00.7	106 23 30.0	300 x 250 см	Булш
2	Сөн толгой-02	49 17 00.9	106 23 30.4	300 x 300 см	Булш
3	Сөн толгой-03	49 17 01.2	106 23 30.7	230 см	Булш
4	Сөн толгой-04	49 17 01.9	106 23 26.2	320 см	Булш



Зураг 4. Археологийн олдворын байршил

Угсаатны зүйн судалгаа: Судалгааны ажилд тус компаний ашиглалтын талбайн нөлөөллийн бүсэд хамгийн ойр орших Дархан-Уул аймгийн Хонгор сумын II багийн хоёр иргэн хамрагдсан байна.

Судалгааны ажлаар нөлөөллийн бүсэд ойр орших “Дархан” уулыг нутгийн ард түмэн эртнээс шүтлэгтэй уул хэмээн хүндэтгэн дээдэлж өөрсдийн үр хүүхэд, ажил үйлсээ даатган ирсэн уламжлалтай ажээ. Мөн нөлөөллийн бүсэд тодорхой хэмжээнд малчин иргэдийн бэлчээрийн талбай багтсан болно.

Түүнчлэн аливаа газарт үйл ажиллагааг эрхлэх, бүтээн байгуулалт зэргийг явуулахад тодорхой хэмжээнд замын асуудал яригдаж байна. Тиймээс тухайн судалгаа хийгдсэн бүс орчмын газарт болгоомжтой хандах, компанийн үйл ажиллагааны тухай ялангуяа зорилго, хугацаа, ач холбогдлын талаар нутгийн ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж, ахуй амьдрал, бэлчээр-ус, өвөлжөө, хаваржаа, зэрэг эртнээс өвлөгдөн ирсэн монгол ахуй соёлын уламжлалт байдлыг харгалзан үзэж хүндэтгэлтэй хандах шаардлагатай юм.

Түүх, соёлын өв: Хонгор сумын түүх, соёлын өв, дурсгалт газрын тухайд гэвэл Эртний хүннүгийн чулуун булш, Эртний сүг зураг, Чингис хааны бичигт хад, жанжин Сүхбаатарын үдэлж, жанжин туг хоногдсон газар Мухар, Могой, Хүйтний гол, Зочин хад, Зулзагын гол, Өвөр булаг, Амгалан толгой, Дээд буурт гэх зэрэг газрууд байдаг. Эдгээрийн талаарх мэдээлэл хомс байдаг байна. Үүнээс гадна хоёр зууны өмнөөс Монголын тал нутгаар дайран өнгөрөх тэмээн жингийн зам уг газраар дайран өнгөрдөг байсны баримт өнөөдөр Өрмөгтэй уулын энгэрээс урагш чиглэсэн Зулзагын голыг дайран гардаг байсныг гэрчлэх номтын гүүрийн хууччин үлдэц, шон мод байгааг хүрээлэнгийн судлаачид олж тогтоон байршлыг нь тэмдэглэж, зургаар баримтжуулсан байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумы нийгэм эдийн засаг:

Дархан – Уул аймгийн Хонгор сум нь БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 4-р сарын 19-ны 85 дугаар зарилгаар Сэлэнгэ аймгийн Хонгор сум Дархан САА-г харъялан үйл ажиллагаагаа явуулж байгаад 1982 оны 105 дугаар зарилгаар Дархан хотын Хонгор хороо, Монгол Улсын Их хурлын 1994 оны 05-р сарын 06-ны 32 дугаар тогтоолоор Салхит хороог татан буулгаж нийлүүлэн Дархан-Уул аймгийн Хонгор сум болгон үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ аймгийн Ерөө, Жавхлант, Мандал, Баянгол, Сайхан сумдтай хил залгаа оршиж нийслэлээс 250 км, аймгийн төвөөс 25 км зайтай Улаанбаатар Сэлэнгийн авто зам, хилийн Замын-Үүд Алтанбулаг боомттой холбосон төмөр замын зангилаан дээр оршдог байршлын өвөрмөц онцлог, эдийн засгийн хөгжлийн бүтэц сайтай сум юм.

Хүн ам: 2019 оны жилийн эцсийн байдлаар 3 багийн 1535 өрхөд 5861 хүн амьдарч байна. 2018 оны нийт хүн амын тоог 2019 оны хүн амын тоотой харьцуулж үзвэл 254 хүнээр буюу 4.1 хувиар, өрхийн хувьд 70 өрхөөр буюу 4.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт хүн амын 52.7 хувь нь буюу 3088 нь эмэгтэй, 47.3 хувь нь буюу 2773 нь эрэгтэйчүүд байна. 2019 оны байдлаар нийт хүн амын 1724 нь буюу 29,4 хувь нь 0-15 насны хүүхдүүд, 1787 нь буюу 30.5 хувь нь 15-35 насны залуучууд, 2350 нь буюу 40.1 хувь нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

Эрүүл мэнд:

Эрүүл мэндийн төв Буурал багийн төвийн байршилтай. 6 ортой, 3 их эмч, 5 сувилагч, 23 ажилчидтай ажиллаж байна. 1969 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, зориулалтын барилга, инженерийн бие даасан хангамжгүй. Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангахгүй байгаа тул тус барилгыг эмийн бус эмчилгээний хэсэг болгож, шинээр барилгын өргөтгөл хийх шаардлагатай.

Боловсрол:

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 43 бүлэгт 893 хүүхэд өдрөөр суралцаж байна. Хамран сургалт 94,3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100 хувьтай байгаа ба мэргэжлийн хөрвөх сургалтанд 6 багш суралцаж төгссөн, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 41 багш хамрагдсан байна. 2 багийн дотуур байранд 114 хүүхэд хүмүүжиж байна. Төрийн өмчийн 16-р цэцэрлэгийн үндсэн сургалтанд 100, гэр цэцэрлэгт 50 хүүхэд хамрагдаж байна. Салхит багийн төмөр замын Чандага цэцэрлэгт 94 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.


Ерөнхий боловсролн 12 жилийн 11-р дунд сургууль Салхит багийн Төвийн хэсэгт байрладаг. Хичээлийн А байр нь 1978 онд ашиглалтанд орсон 330 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 330 хүүхэд суралцаж байна. 8 багш, ажилчидтай, хичээлийн Б байр нь 2007 онд ашиглалтанд орсон, инженерийн бие даасан хангамжтай, тоосгон хийцтэй, чанар сайтай шинэ барилгатай. Сургуулийн дотуур байранд нийт 38 хүүхэд хамрагддаг.

ЦЭЦЭРЛЭГ: 16-р цэцэрлэг нь Буурал багийн нутагт байршилтай 100 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 100 хүүхэд хүмүүжиж байна. 23 багш, ажиллагчидтай, 1969 онд ашиглалтанд тоосгон хийцтэй, зориулалтын барилга. Инженерийн төвлөрсөн хангамжтай. 2012 онд 1 ангийн өргөтгөл шинээр барьсан Зуны улиралд гэр цэцэрлэгээр 50 хүүхэд хамрагдаж байгаа, 16-р цэцэрлэгт спорт, урлагийн заал барихгүйгээс хүүхдүүд бүтэн өдрийн турш ангидаа байдаг.

Мал аж, ахуй:

Хонгор сумын эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар тэргүүлэх байр суурьтай байсаар ирсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Нийт малын тоо толгой сүүлийн 5 жил 150.0 мянгаас 191.54 мянга болж өссөн байна.




Хонгор сумын нийт малын 51%-ийг хонин сүрэг, 35%-ийг ямаан сүрэг, 9%-ийг үхэр сүрэг, 5%-ийг адуун сүрэг тус тус эзэлж байна. Сумын хэмжээнд 764 өрх малтай бөгөөд үүнээс 520 нь малчин өрх байна. Сумын хэмжээнд 191540 толгой мал тоологдсон байна.

Газар тариалан:

Сумын хэмжээнд нийт 32200 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 3 хувьд нь төмс, 0,6 хувьд хүнсний ногоо, 80 хувьд нь улаанбуудай, 16,4 хувьд тосны ургамал, малын тэжээл тариалж, уринш буудай тариалж байна. 2012 онд нийт 13586,1 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 8985,9 га, тосны ургамал 3800,2 га, малын тэжээл, эрдэнэшиш, овъёос 317 га, төмс 400 га, хүнсний ногоо 83 га талбайд тус тус тариалж, 13301,4 га талбайд уриншийн боловсруулалт хийсэн нь нийт эргэлтийн талбайн 86,7 хувийг эргэлтэнд оруулсан байна. 2012 онд уриншийн боловсруулалтыг 13,7 мянган га талбайд хийснээс 1-р боловсруулалтыг 13,3 мянган га талбайд хийснээс 10490 га талбайд химийн, 2-р боловсруулалтыг 11,6 мянган га талбайд хийснээс 8333,6 га талбайд химийн, 3-р боловсруулалтыг 711 га талбайд хийсэн байна. Төслийн талбай нь Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрлана.

2-р баг нь 2019 оны жилийн эцэст хүн амын тоо 1837-д хүрсэн бөгөөд өмнөх оноос 3.1



хувиар буурсан боловч нийт өрхийн тоо 2 өрхөөр нэмэгдэж 498 болсон байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 55, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 45 байгаа бол 0-14 насны хүүхэд 32.1, 15-59 насны хүн 61, 60-аас дээш насны хүмүүс 6.9 хувийг эзэлж байна. Сумын нийт хүн амын 31.3 хувь нь 2-р багт хамаарна. Сумын хэмжээнд нэг өрхөд ногдох хүний тоо 2019 оны байдлаар 3.3 – 4.3 байгаагаас 2-р багт нэг өрх

дунджаар 3.6 гишүүнтэй байна.

Мал аж ахуй хувьд:

Сумын нийт малын 74.5 хувь нь тус багт байдаг ба 2-р баг нь нийт 142810 толгой малтай ба үүнээс малын 53.5%-ийг хонин сүрэг, 32.9%-ийг ямаан сүрэг, 8.4%-ийг үхэр сүрэг, 5.2%-ийг адуун сүрэг тус тус эзэлж байна.

БҮЛЭГ ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлов. Нөлөөллийн хэмжээ үлэмж их байвал цааш нарийн судалгаа хийх бөгөөд нөлөөллийн хэмжээ бага тохиолдолд цааш судлах шаардлагагүй гэж үзэв.

Нөлөөллийн хэмжээг дараах 3 хүчин зүйлээр тодорхойлсон. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал. Нөлөөлөл тус бүрд дээр дурьдсан хүчин зүйл болгоноор 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна.

Хүснэгт 11. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ тархалтын түвшин үзүүлэлт

Хэмжээ тархалт (M) 1 , 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг (бага, дунд, их) тодорхойлно. Мөн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хугацааг тодорхойлно.
Хамрах хүрээ (S) 1 , 2 ба 3	Төслийн үйл ажиллагааны нөлөөлөх газарзүйн байрлал, сум орон нутаг, болон үйлдвэрийн талбайг хамарна.
Давтамж / магадлал (F) 1 , 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Эх сурвалж: Монгол улсын байгаль орчны стратеги үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны аудитын өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох үнэлгээний ажлын тайлан, 2009, хуудас 41.

Алтны шороон орд ашиглах явцад болзошгүй нөлөөллийг хэмжихийн тулд хэмжээ-тархалт, хамрах хүрээ, давтамж гурвыг үржүүлж тооцож дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12. Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ

